



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 84

Эрдэнэт

Зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Төр, сүм, хийдийн харилцааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Аймгийн нутаг дэвсгэрт сүм, хийд шашны байгууллага байгуулж, үйл ажиллагаа явуулах журмын 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. "Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Эрдэнэт цуглаан" шашны байгууллагын үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг нэг жилийн хугацаагаар олгосугай.

2. Хууль тогтоомж, дүрмийнхээ дагуу үйл ажиллагаа явуулах, дүрэмд орсон нэмэлт өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэж байх, жил бүрийн тогтоосон хугацаанд үйл ажиллагааны тайлангаа аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд албан ёсоор ирүүлж байхыг "Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Эрдэнэт цуглаан" шашны байгууллагын удирдлагад үүрэг болгосугай.



ДАРГА:

P. Purenkhagva

П.ПҮРЭВЛХАГВА